

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ТҮҮХЭН ХӨГЖЛИЙН АСУУДАЛД

Д.Моломжамц*, Б.Хишигдэлгэр**

Хураангуй: Хүмүүс суурьшмал амьдрал, нийгмийн нарийн зохион байгуулалтанд шилжиж эхэлсэн тэр үеэс хоол хүнс, тариа будаа, ан гөрөө, өмч хөрөнгийг тэмдэглэх зорилгоор элдэв дүрс зургийг ашиглаж эхэлсэн. Энэ бүхэн нь бичиг үсэг үүсэх эхлэл болсон бөгөөд бичиг үсэг буй болсон нь орчин үеийн нягтлан бодох бүртгэлийн үндэс суурь болсон аж ахуйн бүртгэл үүсэж хөгжихөд чухал алхам болсон байна. Үүнээс үзвэл нягтлан бодох бүртгэл нь хүн төрөлхтний оршин тогтнол, хөгжил дэвшлийн ололт амжилттай салшгүй холбоотой нэн эртний мэргэжлийн нэг юм. Хүн төрөлхтний хөгжил дэвшлийн түүх бол үйлдвэрлэл, бараа таваар, эд баялаг, өмч хөрөнгийг буй болгохтой салшгүй холбоотой. Өмч хөрөнгө, эд баялагийн түүх бол түүний бүртгэл тооцоо, өөрөөр хэлбэл аж ахуйн болон нягтлан бодох бүртгэлийн түүх билээ. Энэхүү өгүүлэлд МЭӨ 3500 – аад оны үед Эртний соёл иргэншлийн өлгий нутаг Меспотамид анх үүссэн гэж үздэг аж ахуйн бүртгэлийн элементүүд Эртний Египет → Грек → Ромын эзэнт улсуудаар дамжин улам боловсронгуй болон хөгжсөөр Дундад эртний болон дундад зууны үед Европын томоохон улс орнууд болох Итали → Франц → Герман → Англи улсуудын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшилтэй уялдан өнөөгийн Нягтлан бодох бүртгэл хэрхэн үүсэж буй болсон, түүнийг Орос улс бүтээлчээр нэвтрүүлэн улмаар 20-р зууны эхээр Монгол улсад шинжлэх ухааны үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийг хэрхэн хөгжүүлсэн тухай түүхийг товч авч үзэв.

Түлхүүр үг: аж ахуйн бүртгэл, хөдөө аж ахуй, газар тариалан, худалдаа, аж үйлдвэр, данс, давхар бичилт, журнал, санамжийн дэвтэр, ерөнхий дэвтэр, нягтлан бодох бүртгэл

* МУИС, Бизнесийн сургууль, (E-mail) molomjamts0112@yahoo.co.jp

** МУИС, ШУС, Хүмүүнлэгийн ухааны сургууль, (E-mail) hishge75@yahoo.co.jp

I. ЭРТНИЙ ДЭЛХИЙ ДАХИНД АЖ АХУЙН БҮРТГЭЛ ҮҮСЭЖ ХӨГЖСӨН НЬ

1.1 Эртний Месопотамид аж ахуйн бүртгэл үүсэж хөгжсөн нь

Бичиглэлийн хамгийн эртний хэлбэр болох Ойрхи Дорнодоос гаралтай тооллын тэмдгийг 30 мянган жилийн түүхтэй гэж үздэг. Эртний хүмүүс ан гөрөө, хоол хүнснийхээ илүүдлийг мод чулуу, хад асга, агуйн хананд тэмдэглэдэг байсан ул мөр, археологийн олдворууд байдаг хэдий ч эрдэмтэд орчин үеийн нягтлан бодох бүртгэлийн үндэс суурь болсон аж ахуйн бүртгэлийн үүслийг хүрэл зэвсгийн эхэн үетэй холбон авч үзсэн байдаг.

Хүрэл зэвсгийн эхэн үе буюу МЭӨ 3500 – гаад оны үеэс хүмүүс зохион байгуулалтанд орж хамтран амьдрах болсноор бүтцийн хувьд илүү тодорхой зааг ялгаа бүхий нийгэм үүсчээ. Ийм нийгэмд мэдээлэл, харилцааны илүү боловсронгуй механизм, итгэл бишрэлийн илүү нарийн тогтолцоо үүсч хөгжин суурин амьдралын соёл иргэншил бий болсон байна. (Адам Харт – Дэвис, 2009)

Тигр, Евфрат, Нил, Инд, Хөх ба Шар мөрөн зэрэг томоохон гол мөрний үржил шимтэй хөрс бүхий өргөн уудам хөндий, сав газарт хүмүүс төвлөрөн суурьшсанаар анхны нарийн зохион байгуулалтат нийгэм, соёл иргэншлүүд буй болсон. Газар тариаланд усжуулалтын системийг хөгжүүлснээр ургацын хэмжээ нэмэгдэж хүмүүс зөвхөн газар тариалан эрхлэх бус улмаар гар урлал, жижиг үйлдвэрлэл, арилжаа наймаа эрхлэх болсноор хотууд бий болсон. Түүнчлэн бичиг үсэг үүссэн зэрэг нь аж ахуйн бүртгэл үүсэж хөгжих үндэс суурь болжээ.

Месопотами (Μεσοποταμία) гэдэг нь гол мөрнүүдийн дундах газар нутаг гэсэн утгатай Грек үгнээс гаралтай. Энэ газар нутаг нь өнөөгийн Ирак болон баруун өмнөд Иран, дорнод Сири, зүүн өмнөд Туркийг хамарсан нутаг буюу Тигр, Евфрат мөрний хооронд орших газар тариалангийн үржил шимт өргөн уудам хөндий юм. Месопотамийн хөндийд МЭӨ 6000 жилийн тэртээгээс тариачид суурьшин амьдарч эхэлсэн гэж үздэг. Энэ газар нутаг нь тариалан эрхлэхэд тохиромжтой үржил шимтэйгээс гадна худалдааны олон замын уулзвар болж байсан.

Одоогоос 5500 гаруй жилийн тэртээ эртний соёл иргэншлийн өлгий нутаг Месопотамийн хөндийд цэцэглэн хөгжиж байсан Ассир, Вавилон болон Шумерийн хот улсуудад худалдаа арилжааг тэмдэглэж байсан тухай баримт нь хамгийн эртнийхэд тооцогддог. Энэ үед худалдааг хянахад шаардлагатай

байсан бүртгэлийн тогтолцоо нь дүрс — зургийг агуулсан тэмдэглэгээнээс бүрдэж байсан бөгөөд үүнээс анхны бичиг үсэг үүссэн гэж үздэг байна. Цаг хугацааны явцад бичих үйл явцыг хурдан бөгөөд хялбар болгохын тулд дүрс — зургийг хялбаршуулж товчилсон.

Эртний Месопотамид энэхүү дүрс — зургийг хялбаршуулснаар шаантаг хэлбэртэй буюу кунейформ (*кунейформ* — латинаар шаантаг хэлбэр гэсэн утгатай) маягийн анхны бичиг үсэг үүсч бий болсон байна. Тэр үед нойтон шавар дээр хэв дарж, шаантаг хэлбэрт дүрсийг гаргаж авдаг байсан. (Адам Харт — Дэвис, 2009)

Энэхүү шаантаг хэлбэртэй дардсыг ашиглан нилээд бөх шавар самбар дээр тэр үеийн худалдаа наймаа, гэрээ хэлцлийн талаар бичдэг байжээ.

Нойтон шаврыг хэвэнд оруулан гаргаж авсан тодорхой хэмжээ бүхий хэлбэр дүрс нь арилжаа наймааны талаарх гэрээ хэлцлийн хугацаа, нөхцлийг тэмдэглэж байв. Гурвалжин үзүүртэй модон саваа, шаантган бичиг зэргийг ашиглан гэрээ хэлцэл байгуулж буй талуудын нэр, солилцож буй бараа, эд зүйл болон мөнгө, түүнчлэн бусад амлалтуудыг тэмдэглэдэг байсан байна. Гэрээ байгуулагч талууд уг гэрээ хэлцлийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өөрсдийн нэрийг төлөөлүүлсэн тамгыг самбар дээр дарж баталгаажуулдаг байжээ.

Хүмүүсийн ихэнх нь бичиг үсэг мэддэггүй байсан тэр үед хүмүүс өөрийн тамга буюу сийлбэртэй чулуун сахиусыг хүзүүндээ зүүж явдаг байсан бөгөөд тэднийг нас барахад уг сахиустай нь хамт оршуулдаг байсан. Ийм тамга нь гол төлөв эзнийхээ нэр болон шашин шүтлэгийн билэг тэмдэг, түүнчлэн тахин шүтдэг бурхны нэр болон зургийг агуулдаг байв.

Зэгсээр хийдэг муутуу цаас нь энэ цаг үед маш ховор, олдоц муутай бас үнэтэй байсан бол энэ бүс нутагт шавар элбэг байсан нь шавар самбар бүхий шаантган бичгийг өргөн хэрэглэх үндсэн шалтгаан болсон. Түүнээс гадна муутуу цаас, хулс, илэг зэрэг амархан элэгддэг материал нь олон зууныг дамжин өнөөг хүртэл хадгалагдан ирж чадаагүй, харин сайтар бэхэжүүлсэн ийм шавар шаантган бичээс нь бусад материалыг бодвол илүү бат бөх учраас өнөөг хүртэл олноороо хадгалагдан үлдсэн байдаг. Тэр үеийн засаг захиргаа, сүм хийд, аж ахуй эрхлэгчид ийм шавар самбар бүхий шаантган бичгийг олноор нь хэрэглэж байсан нь орчин үеийн бичиг үсэг үүсэх эхлэл болсон гэж үздэг.

Үүний зэрэгцээ арилжаа наймааны гэрээ хэлэлцээрийг зөрчсөн тохиолдолд торгож шийтгэхтэй холбогдсон хууль, дүрэм журмыг боловсруулж эхэлсэн. Эдгээрээс хамгийн алдартай нь хуучин Вавилоны (МЭӨ 1894 – 1595 оны орчим) Хаммураби хааны (МЭӨ 1792 – 1750 оны орчим) засаглалын үед түүний нэрээр нэрлэгдэж байсан Вавилоны ахуй амьдралын тухай баялаг мэдээлэл агуулсан хуулиуд юм. Тухайлбал, Хаммураби хааны зарим хуулиар арилжаа наймаанд оролцогчдын үүрэг хариуцлагыг тодорхойлох, тэдний хооронд үүсэх эдийн засгийн харилцааг зохицуулахыг оролдож байв. Энэ үед өмчийн эзэн худалдаачинд өгсөн бараагаа хэлэлцэж тохирсон үнээр зарж борлуулахыг шаардах эрхтэй бөгөөд үүнийг зөрчсөн тохиолдолд тэдгээрийн хооронд байгуулсан гэрээ хэлцэл хүчингүй болдог байжээ. Энэ бүхэн нь хоёр тал харилцан тохирч зөвшөөрсөн ихэнх арилжаа наймаа нь тухайн гэрээний хугацаанд найдвартай явагдах үндэс болж байв. (John R. Alexander, 2002)

Газар тариалангийн нэг адилаар Месопотамийн хөндийд хүмүүс жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхэлж холбоо харилцаа хурдацтай хөгжиж байв. Вавилон болон Нинэвэх хотууд нь энэ бүс нутгийн худалдаа арилжааны гол төв нь байсан бөгөөд ялангуяа Вавилон нь Ойрхи Дорнодын улс төр, бизнесийн зангилаа төв болж байв. Тэнд Месопотами дахь хэд хэдэн банктэй төстэй байгууллагууд байсан бөгөөд тэдгээр нь алт, мөнгөний тогтсон хэмжүүрийг ашиглахын зэрэгцээ арилжаа наймаанд зээл олгодог байв.

МЭӨ 3500 – аас 500 он хүртэлх хугацаанд Шумерт засаглалын эрх мэдлийг үе залгамжлан барьж байсан бөгөөд тэдгээр төр баригчид бурханы нэрийн өмнөөс ихэнх газар, мал сүргийг өөрсдийн мэдэлд захиран зарцуулж байсан нь бүртгэл хөтлөх үйл явцад түлхэц болсон байна.

1.2 Эртний Египетийн аж ахуйн бүртгэлийн онцлог

Эртний Египетийн хаант улс (МЭӨ 2686 – 2181 он) үржил шимт Нил мөрний хөндийд цэцэглэн хөгжсөн. Энэ гайхамшигт мөрөн Африк тивийн зүүн умард хэсэгт орших өргөн уудам хөндий дундуур урсдаг. Умар зүг буюу Доод Египетэд Нил мөрөн салаалан урсаж, өргөн уудам, үржил шимтэй бэлчирийг үүсгэх бөгөөд чухамхүү энд л хүмүүс төвлөрөн суурьшиж иржээ. Нил мөрөн жил бүр үерлэдэгээс газрын хөрс нь үржил шимтэй хар шороон хөрс болсон нь үр тариа тарихад тохиромжтой байв. Тариалангийн том талбайг услахын тулд томоохон усалтын байгууламжуудыг зохион бүтээв. Мөрний сав газар дахь чийглэг газарт хүнсэнд хэрэглэх усны шувууд байхаас гадна бичгийн хэрэгсэл болох муутуу цаас хийдэг зэгс ургана. (Адам Харт – Дэвис, 2009)

Эртний Египетийн хаант улсыг хэмжээлшгүй эрхт мэдэлт фараонаар удирдуулсан төвлөрсөн төр хатуу чангаар удирдаж байв. Фараонуудыг бурхад болон тэдний албатуудыг хооронд нь холбох үүрэг бүхий хагас хүн, хагас бурхан хэмээн бишрэн шүтнэ. Энэ үзэл тухайн үеийн Египетийн аж амьдрал, улс төр, шашин шүтлэгийн амин сүнс болдог байв. (Адам Харт – Дэвис, 2009)

Эртний Египетийн төр, засаг захиргааны аж ахуйн бүртгэл нь Месопотамийн бүртгэлтэй ижил төстэй, адил хэв маягаар хөгжиж байсан. Гэхдээ худалдаа наймааг шавар самбараас илүү муутуу цаасан дээр тэмдэглэж байсан нь бүртгэл хөтлөхөд илүү хялбар дөхөм байв. Тиймээс эртний Египетийн аж ахуйн бүртгэл нь нилээд тодорхой, нарийвчилсан, ялангуяа Фараонуудын сан хөмрөгт татвараар орж ирсэн эд зүйл, бараа таваарыг нягт нямбай бүртгэдэг байснаараа онцлогтой. (Соколов Я.В, 2006)

Данс тооцоо хөтлөгчид Фараоны сан хөмрөгтэй холбоотой тооцоог нарийн бодож боловсруулсан дотоод хяналтын системээр дамжуулан хянадаг байв. Энэ үеийн данс хөтлөгчид тооцоог үнэн зөв, алдаа мадаггүй бэлтгэдэг байсан. Учир нь данс тооцоог будилуулсан нь Фараоны хяналт шалгалтаар илэрвэл тэдэнд торгууль оноох, зодож шийтгэх, бүр цаазлах ял оноох зэргээр хатуу арга хэмжээ авдаг байв. Гэсэн хэдий ч эртний Египетийн аж ахуйн бүртгэл нь мянган жилийнхээ түүхэнд энгийн бүртгэлээс цааш урагшлаагүй. Үүнд олон хүчин зүйл нөлөөлсөн бөгөөд ялангуяа тэр үед зоосон мөнгөний хомсдол, нийтээр бичиг үсэг үл мэдэх явдал их байсан зэрэгтэй илүү холбоотой гэж үздэг.

1.3 Эртний Грекийн аж ахуйн бүртгэлийн онцлог

Эртний Грек нь нэгдмэл нэг улс байгаагүй бөгөөд олон жижиг хот-улсуудаас бүрдэж байв. Эдгээр хот-улсууд нь өөрөө өөрийгөө захирдаг, бие даасан шинжтэй, хууль эрх зүйн тогтолцоотой байсан. Тиймээс эртний Грекийн соёл иргэншлийн гол төв нь МЭӨ VII – V зууны үед Афин, Спарт, Коринт, Тебэс зэрэг хот-улсууд болж байв. (Адам Харт – Дэвис, 2009)

Эдгээр хот-улсуудын үед Милетийн Фалес, Пифагор, Демокрит, Платон, Аристотель зэрэг аугаа философичид, суут сэтгэгчид төрж, Эпидаурын театр, Аполлоны сүм, Парфенон сүм зэрэг алдарт уран барилгуудыг барьж байгуулснаас гадна энд уран баримал, урлаг, уран зохиол, анагаах ухаан, математик, геометр, байгалийн шинжлэл эрчимтэй хөгжиж байв. Түүнчлэн Афин, Спарт зэрэг хот улсуудад засаглалын янз бүрийн хэлбэрүүд, хотын

зөвлөл, иргэдийн оролцоо бүхий иргэдийн хурал, иргэдийн төлөөлөгч бүхий шүүх зэрэг ардчилсан төрийн анхны үзэл санаа бий болж байсан. Эртний Грекийн нийгэм, улс төр, соёл, оюуны сэтгэлгээний эдгээр өвөрмөц онцлогууд нь хүн ардын ахуй амьдрал, худалдаа арилжаа, аж ахуйн бүртгэлийн хөгжилд зохих нөлөө үзүүлсэн байна.

Тиймээс судлаачид эртний Грекийн аж ахуйн бүртгэлийн онцлогийг 1). Аж ахуйн тэмдэглэл хөтөлж байсан баримт, ул мөр; 2). Хууль эрх зүйн баримтууд; 3). Уран илтгэгчдийн хэлсэн үг; 4). Гүн ухааны үг хэллэг; 5). Урлагийн бүтээлийн талаарх мэдлэг зэргийг судалсны үндсэн дээр тодорхойлсон байдаг.

Эртний Грекэд жижиг самбар, цайруулсан гөлтгөнө, муутуу цаас, шавар ваарыг ашиглан аж ахуйн бүртгэлийг хөтөлдөг байсан. Грек бол тооцооны хэрэгсэл анх үүссэн газар орон юм. Энд анх зоосон хэлбэрээр мөнгийг төлбөр тооцоонд ашиглаж эхэлсэн гэж үздэг. Мөнгө нь эхэн үедээ аж ахуйн бүртгэлийн бие даасан объект болж байсан бол дараа нь тооцооны хэрэгсэл, үүний дараа эд хөрөнгийг хэмжих өртгийн хэмжүүрийн үүргийг гүйцэтгэх болсон байна.

Эртний Грекэд 1). Материалын бүртгэл буюу эд хогшлыг данслах 2). Тооцооны бүртгэл буюу харилцах данс (контокоррент) гэсэн хоёр эх үүсвэрээс нягтлан бодох бүртгэл үүсэж хөгжсөн гэж үздэг. (Соколов Я.В, 2006)

Афинд улсын орлого, зарлагын талаарх тайлан бэлтгэх үүрэг бүхий тусгай түшмэл, хянан шалгагчид ажиллаж байсан. Ийм ажил хариуцдаг арав орчим хүний мэдэлд санхүүгийн бүртгэл ба хяналтын үйл ажиллагаа төвлөрч тэд улсын орлого, зарлагын бүх бүртгэл, сүм дуганын хөрөнгийн бүртгэл, үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг данслах зэрэг үйл ажиллагааг хийж гүйцэтгэдэг байжээ. Зөвхөн улсын сан хөмрөгт орсон болон гарсан бэлэн мөнгөний мэдээ баримтыг бүртгээд зогсохгүй энд төлбөр тооцоо хийх, бусад кассанд төлбөр тооцоог шилжүүлэх зэрэг ажлуудыг хийдэг байв.

Орлогын төрөл тус бүр дээр тодорхой үсгээр тэмдэглэсэн тусгай домбо нээж, тодорхой зардлыг зөвхөн тухайн зориулалтын мөнгө бүхий домбоноос авч зарцуулдаг байсан нь орлого ба зардлыг өөр хооронд нь уялдаатайгаар авч үзэх, улмаар орлогыг зөв зарцуулах, зардлыг хянах анхны оролдлого байсан гэж үзэж болно.

Бэлэн мөнгөний кассын түлхүүр нэг түшмэлийн мэдэлд байдаг, харин уг

касс байрлах байшингийн түлхүүр нь баримт материалын хамт өөр нэг түшмэлд хадгалагдах ба тэднийг хоорондоо түлхүүрээ солилцохыг хатуу хориглодог байв. Төлбөр тооцооны баримтуудыг тодорхой хугацаагаар хуваарилж хадгалдаг. Түшмэлүүд хугацаа хожимдсон төлбөр болон төлбөр төлөөгүй этгээдийн талаарх мэдээ бүхий жагсаалтыг буцааж өгөх, төлбөр төлөгчийг хасах, бэлэн мөнгө хүлээн авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэдэг байв. Ингэж эртний Грекэд анх хөрөнгө, төлбөр тооцооны тэмдэглэлийн жагсаалт үүссэн.

Афинд бүртгэл тайлагнал нь олон нийтийн шинжтэй байсан. Сүм дугана, төрийн байгууллагууд тайлангаа гантиг болон хүрэл самбар дээр бичиж тэмдэглэн ардын хуралд илгээн, сүмийн хашаа хайс, зам дагуу газар байрлуулж хүн ардад үзүүлж харуулдаг байсан. Мөн үүний зэрэгцээ Эртний Грекэд банкны систем хөгжиж байсан бөгөөд тэдгээр нь орлогын болон зарлагын гүйлгээг бүртгэх хоёр төрлийн журналыг ашигладаг байв. Мөн эдлэн газар нь таваар болохын зэрэгцээ эзэлийн барьцаа болдог байсан. (Соколов Я.В, 2006)

Суут Аристотель өөрийн “Улс төр” хэмээх бүтээлдээ бүртгэлийн үүргийг хяналт шалгалтаас тодорхой заагласан байдаг. Энэ бүхэн Эртний Грекийн аж ахуйн бүртгэлийн үүсэл, хөгжлийн өвөрмөц онцлогийг илтгэн харуулдаг байна.

1.4 Эртний Ромын аж ахуйн бүртгэлийн онцлог

Эртний Ромд цагаан лаваар бүрсэн жижиг самбар, зэс самбар, арьс шир, зотон, илэг, муутуу цаас зэрэг материалыг ашиглан аж ахуйн бүртгэлийг хөтөлдөг байв. Ерөнхийдөө эртний Ромд эртний Грекийн аж ахуйн бүртгэлийн бүртгэлийн үндсэн дээр хөгжсөн харилцан уялдаа холбоо бүхий бүртгэлийн систем оршин тогтнож байжээ. Эртний Ромын бүртгэлийн систем дэх анхны данс тооцооны дэвтэр нь аж ахуйн үйл ажиллагааны өдөр тутмын баримт мэдээний бичилтэнд зориулагдсан Санамжийн дэвтэр буюу Мемориал байсан. Түүнчлэн данс бүртгэлтэй холбоотой хоёр дүрэм журам үйлчилдэг байсан. Нэг дэх журам нь — тооцооны данс бүхий кассын дэвтэр хөтлөх, хоёр дахь журам нь — байнгын бичилт хийх зориулалт бүхий дэвтэр хөтлөх явдал юм. (Фролова Т.А, 2010)

Ромд нийт улсын хэмжээнд төсвийн бүртгэл хөгжиж байсан бөгөөд эзэнт гүрний тусгай хязгаар мужид төсөвлөсөн мөнгө болон түүний гүйцэтгэлийг тусгасан “Бревариум” — ыг (*brevarium* — эзэнт улсын дансны дэвтэр гэсэн утгатай латин үг) хөтөлдөг байв. Энэхүү бүртгэл тооцоо нь Ромын эзэнт гүрний дансны дэвтэр гэж нэрлэгддэг байсан бөгөөд үүнээс улсын төсвийн

анхны балансыг харж болдог байв. Судлаачдын үзэж буйгаар Бревариумд дараах онцлог шинжүүд байсан. Үүнд:

- Заавал тодорхой баримтыг үндэслэж бичилт хийдэг.
- Мөнгөн хөрөнгийн бүртгэл болон материалын үнэт зүйлийн бүртгэлийн хооронд нарийн зааг ялгаа, хязгаартай байсан.
- Тухайн үед мөрдөж байсан журмын дагуу бичилт хийсэн мэдээллийн эх үүсвэрийг дээд байгууллагуудын өмнө тогтмол тайлагнадаг.
- Өдөр тутмын бүртгэл дэх цаг хугацааны дэс дараалал бүхий бичилт болон журамд заасан сар бүрийн системчилсэн бичилт нь эхлээд үндсэн орлогыг, дараа нь эхний үлдэгдлийг зааж өгсөн зардлын зүйл ангийг ялгаж бичдэг байсан зэрэг болно. (Соколов Я.В, 2006)

Ромын эзэнт гүрний үед системчилсэн бичилт нь улам өргөжин хөгжсөн. Легионуудын тооцоонд зориулан цэрэг бүрт тусгай хувийн данс нээдэг байсан. Ромын цэргүүдэд жилд гурван удаа цалин пүнлүү олгодог байсан бөгөөд түүнийг мөнгөөр, эсвэл хүнс, гутал хувцас, өвсөөр төлдөг байв. Энэхүү цалин пүнлүүний тооцсон дүнгээс олгож байгаа эд зүйл ба хүнсний өртгийг суутгадаг, өргөл барихаас өөрөөр бодит байдал дээр элдэв татвар байгаагүй гэж үздэг. Хэрэв цэргүүд амь үрэгдвэл мөнгийг данснаас нь хасаж легион, эсвэл түүний удирдлагын орлого болгодог байв.

Цаг хугацааны хувьд үүнээс арай хожуу татварын бүртгэл тооцоотой холбоотойгоор санхүүгийн байгууллагуудад системчилсэн бичилт өргөн дэлгэрсэн. Татвар төлөгч бүрт хувийн данс нээж татвар оногдуулах объект болон түүний үнэлгээ, төрөл бүрийн татварын хувь хэмжээ, татварын нийт дүн зэргийг зааж өгөх болсон.

Эртний Ромд төрийн болон цэрэг армийн санхүүгийн бүртгэл тооцоо нь язгууртан, эрх мэдэлтнүүдийн гарт төвлөрч тэд зарцуулж буй мөнгөтэй холбоотой бүх үйл ажиллагаанд хяналт тавьдаг байсан. Ромын эзэнт гүрний эдийн засгийн хөгжлийн ид үед зээлийн харилцаа эрчимтэй хөгжиж ирсэн. Эртний Ромын үйлдвэрлэл эрхлэгчид бие биедээ мөнгө болон эд зүйлийг зээлдүүлдэг байсан. Гол төлөв сарын эхээр хүүгээ төлдөг байсан тул зээл, төлсөн хүү зэргийг тухайн үеийн хуанлийн нэрээр нэрлэдэг байсан. Ийм хуанлид зөвхөн төлбөрийн дүнг төдийгүй зээлдэгчийн авах хүүгийн авлагыг зааж өгдөг байв. Ийм маягаар хүү тооцох зарчим анх үүссэн байна. Зөвхөн өгсөн болон авсан хөрөнгийн дүнг бүртгэх төдий биш зээлсэн мөнгө ба түүнийг төлж барагдуулах үүрэгтэй холбоотой хууль, эрх зүй үйлчилж байжээ.

Эртний Ромын бүртгэлийн зорилго нь гол төлөв хяналт шалгалт руу чиглэгдэж байсан. Тэр үед хяналт шалгалтын нарийн зохион байгуулалт бүхий аппаратыг байгуулан ажиллаж байсан хэдий ч элдэв заль мэх хэрэглэх, орлогоо нуун дарагдуулах явдал түгээмэл байв. (Соколов Я.В, 2006)

Эртний Ромын аж ахуйн гол салбар нь бусад эртний соёл иргэншлийн нэг адил хөдөө аж ахуй байсан учраас бүртгэлийн зохион байгуулалт нь харьцангуй эдлэн газар, газар тариалангийн онцлог шинжийг агуулж байсан. Гэхдээ аж ахуйн бусад салбарууд, тухайлбал барилгын салбарт байшин барилгыг үнэлэх үед элэгдлийг тооцдог байсан. Үйлдвэрлэлийн салбарт бүх зардлыг орлоготой нь харьцуулах замаар аж ахуйн үйл ажиллагааны үр дүнг тооцдог байсан. Ромын аж ахуйн бүртгэлийн үндсэн дээр эд зүйлийг шууд бүртгэх ба данслах, дараа нь анхан шатны баримтаас тоо мэдээг тодорхой бүртгэлийн объектийн хамт тэмдэглэх үед шууд бус арга бий болсон. Энэ бүхэн эртний Ромын аж ахуйн бүртгэлийн онцлог болж байсан бөгөөд эдгээр нь хожмын нягтлан бодох бүртгэл, хяналт шалгалтын олон асуудлын үндэс суурь болсон гэж үздэг.

Ашигласан материал

1. Адам Харт – Дэвис, ред. *Дэлхийн түүх* Мон судар. 2009
2. Моломжамц, Д. *Санхүү, эдийн засгийн шинжилгээ* УБ. 2016
3. Намжим.Т *Монголын аж ахуй, эдийн засаг – түүхэн гурван үед* УБ. 2000
4. *Нягтлан бодох бүртгэлийн онол* Ред. С.Лодой, С.Лүндэн УБ. 1985
5. *Улсын түүхийн төв архив. Фонд №1 /11/*
6. *Улсын түүхийн төв архив. Фонд №1 /35/*
7. Улсын анхдугаар их хурлын сонин. 2-р дэвтэр
8. Баканов М.И., Шеремет А.Д. *Теория экономического анализа* М, Финансы и статистика М, 1997
9. Панков Д. А. *Бухгалтерский учет и анализ в зарубежных странах: Учебное пособие* Минск. Экоперспектива, 1998
10. Палий В.Ф. *Бухгалтерский учет до и после Лука Пачиоли – Бухгалтерский учет. – 1994. №8*
11. Соколов Я.В. *История бухгалтерского учета – М.: 2006*
12. Фролова Т.А. *Бухгалтерский учет – Таганрог.: 2010*
13. Gleeson-White, Jane, *Double Entry: How the Merchants of Venice Created Modern Finance* New York: Norton 2012
14. Heeffer, Albrecht, *Algebraic partitioning problems from Luca Pacioli's Perugia manuscript* 2010
15. John R. Alexander *History of Accounting* New York, 2002